



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 18 он 06
сарын 18 өдөр

Дугаар 35-1
120

Улаанбаатар
хот



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд "Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд

002353



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 06 дугаар
сарын 14-ны өдөр

Дугаар Хэрг
1365

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЦОЛМОН ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

“Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР



007675




МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.06.15 № 12-1/3846
танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР
ТАНАА**

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон тул тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрч байна.



Ч.ХҮРЭЛБААТАР

0 1019



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33. E-mail: foreign@mojha.gov.mn,
http://www.mojha.gov.mn

2018.06.15 № 1-1/3052

танай _____-ны № _____-т

САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР
ТАНАА

Таны 2018 оны 12-1/3810 тоот албан бичгээр ирүүлсэн "Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.


Ц.НЯМДОРЖ


08 2205
Doc.yam 05.2018

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэлд:

“ҮИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцээд “Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ
БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4-т “Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах” гэж заасан.

Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн орлого, зарлагыг тусгаснаар 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан батлах үндэслэл, шаардлага бий болж байна.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэл нь Улсын Их Хурлын тогтоолын төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн танилцуулга гэсэн бүтэцтэй юм. Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасны дагуу дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан болно.

- Тухайн жилийн орлого, зарлагын гүйцэтгэлийг нийт дүн, хөтөлбөр, төсвийн захирагч болон хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр гаргасан тайлан,
- Татварын зарлагыг хуулийн этгээд болон салбар бүрээр нь холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт гаргасан тайлан,
- Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэлийн тайлан,

- Хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга (хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт болон тасарсан бол шалтгаан),
- Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан болон түүний танилцуулга,

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Тогтоолын төсөл батлагдсанаар улсын төсвийн 2017 оны орлого, зарлагын нийт хэмжээ батлагдаж, төсвийн ашгийг/алдагдлыг/ тодорхойлох боломжтой юм.

Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр хуулийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, төсвийн тухай хуульд заасны дагуу Үндэсний аудитын газраар аудит хийлгэж дүгнэлт гаргуулсан.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.3-т “аудитын дүгнэлт гарснаас хойш ажлын долоон өдрийн дотор нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитын дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасны дагуу “Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвийн 31 ерөнхийлөн захирагчийн 1646 төсөвт байгууллага, нийслэл, дүүргүүд болон 21 аймгийн 5058 төсөвт байгууллагууд, Ирээдүйн өв сан, Тогтворжуулалтын сан болон Нийгмийн даатгалын сангуудын төсвийн гүйцэтгэл хамрагдсан болно. Түүнчлэн төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланд татварын зарлагын тайлан, худалдан авсан ажил, үйлчилгээний тайлан, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүнгийн танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл зэргийг нэгтгэн танилцуулж байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн орлогын гүйцэтгэл 7,274.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 591.1 тэрбум төгрөгөөр давж, нэгдсэн төсвийн зарлага 9,017.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 477.1 тэрбум төгрөгөөр дутуу гарсан байна. Нэгдсэн төсвийн тэнцэл 1,742.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, Дотоодын нийт бүтээгдэхүүний 6.4 хувьтай тэнцэж байна.

Улсын төсвийн гүйцэтгэл

Монгол Улсын 2017 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 5,173.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 446.4 тэрбум төгрөгөөр буюу 9.4 хувиар давж, улсын төсвийн зарлага 7,139.6 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 281.0 тэрбум төгрөгөөр буюу 3.8 хувиар бага байна. Улсын төсвийн тэнцэл 1,966.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Монгол Улсын 2017 оны төсвийн
гүйцэтгэлийг батлах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 5,173,682.6 сая /таван их наяд нэг зуун далан гурван тэрбум зургаан зуун наян хоёр сая зургаан зуун мянган/ төгрөгөөр баталсугай.

2. Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 7,139,637.5 сая /долоон их наяд нэг зуун гучин есөн тэрбум зургаан зуун гучин долоон сая таван зуун мянган/ төгрөгөөр баталсугай.

ГАРЫН ҮСЭГ

“Монгол улсын 2017 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” тогтоолын
төслийн ажлын хэсгийн нэр

№	Нэр	Албан тушаал	Утас
1	Ч.Хүрэлбаатар	Сангийн сайд	
2	Х.Булгантуяа	Сангийн дэд сайд	99110269
3	М.Батхуяг	Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга	99056467
4	Ж.Ганбат	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	99104599
5	Ц.Зоригтбат	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга	99901733
6	Г.Түвдэндорж	Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын дарга	99112910
7	И.Батхүү	Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга	99113569
8	Н.Мөнхсүх	Сангийн яамны Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга	99093348
9	Б.Сүх-Очир	Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга	99011664
10	М.Санжаадорж	Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга	99190219
11	Б.Тэлмүүн	Сангийн яамны Орлогын хэлтсийн дарга	99087638
12	Д.Өлзийсайхан	Сангийн яамны Нэгдсэн төсвийн төлөвлөлтийн хэлтсийн дарга	99109908
13	Л.Сонор	Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга	99066188

--oOo--